



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2019 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 он



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019.12.12

Сайншанд сум

Тус хэлтэс нь 2019 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн иргэдэд төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор **“ШИНЭ ЭРХ ЗҮЙН ОРЧИН- ШИНЭЛЭГ ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ”** зорилтыг дэвшүүлэн ажилласан.

**Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд:**

**“ШИНЭ ЭРХ ЗҮЙН ОРЧИН- ШИНЭЛЭГ ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ”** гэсэн зорилтын хүрээнд хуулиар хүлээсэн үүрэг, бүртгэлийн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Улсын бүртгэлийн багц хууль шинэчлэн батлагдаж, хэрэгжиж эхэлснээр иргэдэд Иргэний улсын бүртгэлийн 10, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2 төрлийн үйлчилгээг харьяалал харгалзахгүйгээр, өөрт байгаа мэдээлэлд үндэслэн иргэдээс бичиг баримт шаардахгүйгээр үйлчилгээг үзүүлж байна.

2. Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ Сайхандулаан, Мандах, Хатанбулаг, Замын-Үүд, Хөвсгөл, Өргөн сум болон Сайншанд сумын 7 багт Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчлэлийн талаарх мэдээллийг 405 иргэнд хүргэж, 58 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

3. Хуулийн шинэтгэл, улсын бүртгэл болон бүртгэл хяналтын чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан, аймгийн хэмжээнд 72 төрийн болон хувийн байгууллагын 2227 албан хаагчид сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

4. Аймгийн нийт хүн амын 30 гаруй хувь нь төвлөрдөг Замын-үүд суманд 2019 онд 3 удаа бүрэн бүрэлдэхүүнээрээ очиж, 4 өдөр ажиллан, хуулийн шинэтгэлийн талаарх мэдээлэл болон улсын бүртгэлийн чиглэлээр 1140 иргэнд мэдээлэл хүргэж, төрийн үйлчилгээг шуурхай хүргэж ажилласан.

5. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсээс зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт 10 удаа, байгууллагаас 12 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж иргэдэд улсын бүртгэлийн багц хууль болон үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг аймгийн нийт хүн амын 3772 иргэн буюу 5,4%-д хүргэсэн.

6. Хуулийн этгээдийн цаасан эх нотлох баримтыг 1 дүгээр улиралд багтаан 100% цахимжуулсан. Жилийн эцэст шинээр бүртгүүлсэн болон мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан хуулийн этгээдийн цаасан эх нотлох баримтыг тухай бүрт цахимжуулж хэвшсэн ба 1654 хуулийн этгээдийн баримтыг цахимжуулсан.

7. Иргэний цахим үнэмлэх болон гадаад паспортын үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй болгох зорилгоор иргэдээс гадаад паспорт авахаар ирүүлсэн хүсэлт материалыг долоо хоног бүр 1-2 удаа, иргэний үнэмлэх дахин авах хүсэлт ирүүлсэн материалыг тухай бүр мэдээллийн санд шивж баталгаажуулдаг. Хэвлэгдэж ирсэн иргэний цахим үнэмлэх болон гадаад паспортыг холбогдох иргэнд мессежээр мэдэгдэх үйлчилгээг нэвтрүүлсэн. Мөн хөдөө сумын иргэдийн хэвлэгдэн ирсэн гадаад паспортыг сумын

бүртгэгчээр дамжуулан олгосон. Тайлант хугацаанд сумдын бүртгэгчээр дамжуулан 2120 иргэний гадаад паспортыг олгосон байна.

8. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 10 жилийн ойгоор 10 бүтээлч ажлыг зохион байгуулж, тайланг УБЕГ-т хүргүүлсэн. Энэ хүрээнд байгууллагын болон эх нотлох баримт бичгийн архивт шалгалт хийж, зөрчлийг арилгахаар төлөвлөгөө гарган ажилласан. Мөн “Дорноговь аймгийн Улсын бүртгэгч нарын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, нэгдсэн арга зүйгээр хангасан.

9. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэмжлэгээр Азийн хөгжлийн банкны 1526,5 мянган төгрөгийн санхүүжилтээр Замын-Үүд сумыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбуулж, онлайн горимд ажилладаг болсон. Жилийн эцсийн байдлаар 1254 иргэнд үйлчилсэн.

#### **Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:**

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2019 оны жилийн эцэст нийт 1053 иргэнд үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнээс

- Төрсний бүртгэлд 1325 /эрэгтэй 687, эмэгтэй 638/
- Гэрлэлт 371 /анхны 327, дахин 42, гэрлэлт сэргээсэн 2/
- Гэрлэлт цуцлалт 109 /Захиргааны журмаар 21, шүүхийн журмаар 88/
- Үрчлэлт -33
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэл-72
- Эцэг тогтоолтын бүртгэл -101
- Нас баралт 373 тус тус бүртгэгдсэн байна.
- 

Мөн мэдээллийн санд бүртгэгдээгүй байсан төрсний болон нас барсны бүртгэл гэрлэлтийн бүртгэлийг нөхөн бичиж УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт нийт 31 бүртгэлийг хүргүүлэн мэдээллийн санд тусгасан.

#### **Иргэний шилжилт хөдөлгөөний чиглэлээр:**

“Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу 2019 оны байдлаар нийт 8335 иргэнд үйлчилгээ үзүүлсний дотор өөр аймаг, нийслэлээс шилжин ирсэн 1459, сумаас шилжин ирсэн 1315, баг хооронд шилжин ирсэн 5561 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулж баталгаажуулсан.

Сайншанд суманд 8 дугаар баг байгуулагдаж, баг хооронд шилжин ирсэн бүртгэлийн тоо өссөн.


#### **Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн чиглэлээр:**

Тус хэлтэс нь мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг ханган онлайн програмд гадаад паспорт хариуцсан улсын бүртгэгчид гадаад паспортын олголтын бүртгэл хийх эрх, гадаад паспорт хүчингүй болгох эрхийг нээлгэсэн.

Хуурамч бичиг баримтын бүрдүүлэлтээс урьдчилан сэргийлж үндэсний энгийн гадаад паспорт шинээр захиалах хүсэлт гаргаж буй иргэний хурууны хээг уншуулж, тухайн иргэний анкетыг хэвлэх үйлчилгээг хийж хэвшсэн.

Тайлант хугацаанд үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтын бүртгэл нийт 16291 /Үндэсний энгийн гадаад паспорт 2845, БНХАУ нэг удаагийн хавсралт 654, БНХАУ олон удаагийн хавсралт 12792/ олгосон.







*Гадаад паспорт ирсэн тухай мессэж мэдээ /*

**Иргэний үнэмлэх олгох ажлын хүрээнд:**

Иргэний үнэмлэх хэвлэх ажлыг тодорхой, тогтмол болгох зорилгоор биеийн давхцахгүй өгөгдлийг хуулбарласан мэдээллийг нэгж дээр тухай бүрд уншуулж, зургийг засварлаж, цахим иргэний үнэмлэхийг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэн үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, иргэний үнэмлэх хэвлэгдэн ирмэгц иргэдэд мессэжээр мэдээлэл хүргэн ажилласан.



*Иргэний цахим үнэмлэх ирсэн тухай мессэж мэдээ /*

Тайлант хугацаанд нийт олгосон иргэний үнэмлэх 4025 үүнээс шинээр олгосон иргэний үнэмлэх 844, иргэний үнэмлэхээ гээгдүүлэн дахин олгосон иргэний үнэмлэх 1330, иргэний үнэмлэхийн хугацаа дуусч 25, 45 насны сунгалт хийлгэсэн 1851 иргэдэд иргэний үнэмлэх олгосон.

Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдах 16 наснаас дээш насны иргэдийн судалгааг гарган хурууны хээг авахаас өмнө мэдээллийн санд шалгаж, илэрсэн алдааг Иргэний бүртгэлийн газарт тухай бүр албан бичгээр хүргүүлж, мэдээллийн санд тусгуулан ажилласан.

Сайншанд сумын иргэний улсын бүртгэгч Г.Нандин-Эрдэнэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байранд хоригдож байгууллагын ялтнуудын болон тэдгээрийн гэр бүлийн хүсэлтийн дагуу 3 ялтны гэр бүлийг цагдан хорих байранд, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийг гэрт нь тус тус очиж бүртгэл хөтөлсөн.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь Монгол Улсын хууль тогтоомж, журмын хүрээнд төрийн албаны ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын стандартыг мөрдлөг болгон иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хууль тогтоомжийн дагуу бүртгэж баталгаажуулах, бүртгэлийн чанар, хяналтыг дээшлүүлэх, архивлагдсан хувийн хэргийн хадгалалтыг сайжруулах, бүртгэлийг Erps програмд бүрэн оруулах зорилготой ажиллалаа.

Тайлант хугацаанд буюу 2019 оны байдлаар хэлтсийн хэмжээнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр иргэн, хуулийн этгээдээс 8315 мэдүүлгийг хүлээн авсан. Үүнээс:

- ✓ Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл -322
- ✓ Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгүүлэх-607
- ✓ Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрх баталгаажуулалт-9
- ✓ Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн анхны бүртгэл -772
- ✓ Газар эзэмших ашиглах эрхийн анхны бүртгэл-1423
- ✓ Худалдах, худалдан авах гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-653
- ✓ Бэлэглэх гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-245
- ✓ Барьцааны гэрээ-4212
- ✓ Өв залгамжлах эрхийн бүртгэл-85
- ✓ Хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ -146
- ✓ Бүртгэлд өөрчлөлт оруулах-179
- ✓ Лавлагаа-886 тус тус бүртгэсэн.

Эд хөрөнгийн эрхийн ерөнхий бүртгэгчийн тушаалаар иргэнээс ирүүлсэн иргэн, хуулийн этгээдээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцуулахаар ирүүлсэн 23 хүсэлт нотлох баримтыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, хүчингүйд тооцсон тухай 23 тушаалыг үндэслэн гэрчилгээг бичиж олгосон.

ШШГГ-ын хүсэлтээр иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэлийн талаарх лавлагааг 144 удаа хүргүүлсэн. Тайлант хугацаанд нийт эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 8315 мэдүүлэг авч, бүртгэн, үйлчилгээний хураамжийн 184857538 төгрөгийг улсын төсөвт, 555635819 төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны татвар, тэмдэгтийн хураамж 25772853 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

### **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”, холбогдох журам, бусад салбар хуулийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн.

Тайлант хугацаанд дараах бүртгэлийг хийсэн. Үүнд:

- Шинээр үүсэн байгуулагдсан нийт 131 хуулийн этгээд бүртгүүлсэн. ХХК-88, нөхөрлөл-17, Төрийн бус байгууллага-17, ТБАГ-1, ҮЭБ-8, шашны байгууллага-1 хуулийн этгээд бүртгэсэн.
- Хуулийн этгээдийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулахаар бүртгэл нийт 166 өргөдөл хүлээн авч, бүртгэсэн.
- Хуулийн этгээдийн мэдээллийн сан, хувийн хэргээс нийт 49 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, хуулбар олгосон.
- Тамга тэмдгийн хяналтын 170 дугаар олгож, 37 хуулийн этгээд тамга, тэмдгийг хураалгасан.
- Хуулийн этгээдийн захиалсан 148 нэрийг журмын дагуу баталгаажуулсан.

Нийт 664 бүртгэл хөтөлж, 9569500 төгрөгийн тэмдэгтийн хураамж төвлөрүүлсэн.

Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан хугацаанд үйл ажиллагааны тайланг ирүүлэх, ирүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.7.3-д зааснаар торгохыг



анхааруулсан мэдэгдэх хуудсыг 168 ТББ-д хүргүүлж, 37 байгууллагаас үйл ажиллагааны тайланг хуулийн хугацаанд ирүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэл, мэдээллийн шинэчилсэн ERS програмыг туршиж, 150 хуулийн этгээдийн хөрвүүлэлтийг тулгаж хүлээн авсан. ERS програмд

Эхний хагас жилийн хугацаанд хураалгасан хуулийн этгээдийн тамга, тэмдгийг 6 дугаар сард акт үйлдэн устгаж, холбогдох баримтыг хадгаламжийн нэгж бүрдүүлэн, эх нотлох баримтын архивт хүлээлгэн өгсөн. Мөн татан буугдсан хуулийн этгээдийн баримтыг хадгаламжийн нэгж бүрдүүлэн хүлээлгэн өгсөн.

Аймагт бүртгэлтэй 16 шашны байгууллагын статистик мэдээллийг нэгтгэн гаргасан. Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 3 шашны байгууллагын статистик мэдээллийг нэгтгэн ХЭУБГ-т хүргүүлсэн. ГБХЗХГ-ын дарга МХЕГ-ын даргын хамтарсан 2019 оны 03 дугаар сарын 28-ны А/41, А/51 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/366 дугаар тушаалаар баталсан “Сүм, хийд, шашны байгууллагуудад хамрагддаг хүүхдийн эрх хамгааллын нөхцөл байдалд судалгаа хийх” ажлын хэсэгт ажиллан, шашны байгууллагын судалгааг нэгтгэсэн.

#### **Архивын ажлын хүрээнд:**

Иргэн, эд хөрөнгийн архивын баримтыг зориулалтын нягтруулсан шүүгээнд, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтыг төмөр тавиурт эмх цэгцтэй байрлуулж, байгууллагын архивт хадгалагдаж буй хадгаламжийн нэгжийг эмх, цэгцтэй, стандартад нийцүүлэх зорилгоор архивын тавиур шинээр хийлгэсэн.

Иргэний баримтын архив болон эд хөрөнгө, хуулийн этгээдийн архивын өрөө нь дотроо галын утаа мэдрэгч, дохиоллын системтэй, галын булантай. Архивын чийг дулаан хэмжилт хэвийн, цахилгааны монтаж далд, цахилгаан үүсгүүр бүхий гэрэлтэй, цэвэрлэгээг хуваарийн дагуу тогтмол хийж хэвшсэн.

Иргэний бүртгэлийн тасагт хадгалагдаж буй иргэний ИУБ маягтууд буюу хувийн хэрэгт байнгын хяналт тавих зорилгоор захиалгын хуудсыг бүрэн гүйцэд хөтөлж хувийн хэргийг олгох, улсын бүртгэгч нарыг архивт өөрийн биеэр ирж захиалгын хуудсаар хувийн хэргээ авч байх, хувийн хэргийг өдөрт нь багтааж архивтаа татан авах, мөн хувийн хэргээ биеэр буцаан архивт хүлээлгэж өгөх, захиалгын хуудсан дээрээ гарын үсгийг тухай бүр зуруулах ажлыг хийж хэвшсэн.

Архиваас гарсан хувийн хэргийг хоёр хоногийн дотор архивт буцааж хүлээн авсан.

Иргэний гэр бүлийн бүртгэлийн мэдээний маягт болох ИУБ-11 маягт 1325 ширхэг, ИУБ-12 маягт 33 ширхэг, ИУБ-13 маягт 72 ширхэг, ИУБ-14 маягт 101 ширхэг, ИУБ-15 маягт 371 ширхэг, ИУБ-16 маягт 97 ширхэг, ИУБ-18 маягт 373 ширхэг, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан болон 25, 45 насны сунгалт хийлгэсэн 2976 ширхэг ИУБ-31 маягт, нийт 5348 ИУБ маягтыг архивын санд байрлуулан, баяжилтыг тухай бүр хийсэн.

Тайлант хугацаанд өөр аймаг хот руу шилжин явсан 587 иргэний хувийн хэргийг холбогдох газарт хүргүүлж, шилжин ирсэн 850 иргэний хувийн хэргийг архивын санд байрлуулсан.

Тус архивт өнөөдрийн байдлаар насанд хүрсэн 56021 иргэний, насанд хүрээгүй хүүхдийн хувийн хэрэг 23109, нас барсан 14525 иргэний хувийн хэрэг, иргэний үнэмлэх аваагүй 124 иргэний, харъяатаас гарсан 96 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн 1654 хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд хуулийн этгээдийн гаргасан 467 өргөдлийн баримтыг хувийн хэрэгт баяжуулсан. Хуулийн этгээдийн бүртгэлийг архив руу шилжүүлснийг ERS програмд архивлах төлөв шилжүүлэн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт үл хөдлөх эд хөрөнгийн 12582, газрын 7244 нийт 19826 хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд энэ онд үл хөдлөх эд хөрөнгийн 929, газар өмчлөх эрхийн 760 хувийн хэрэг шинээр үүссэнийг архивт хүлээн авсан.



Хэлтсийн даргын 2019 оны 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулагдсан төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулж архивын улсын үзлэгт хангалттай үнэлүүлсэн.

**Бүртгэлийн хяналтын ажлын хүрээнд:**

Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд 13 сумын бүртгэгчийн бүртгэлийн ажлыг шалгаж, хэлтсийн даргад илтгэх хуудсаар танилцуулсан. Сумдын бүртгэгчдийн хийсэн 1073 бүртгэл шалгаж, арилгах боломжтой 315 зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

Бүртгэлийн зөрчлийг арилгахаар иргэд болон улсын бүртгэгчдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, тайлбарын дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 52, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 8, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 10, нийт 70 дүгнэлт боловсруулан батлуулж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.

2020 онд сонгууль болохтой холбогдуулан удирдамж боловсруулан хэлтсийн даргаар батлуулан "Иргэний үнэмлэхийн зөрчилгүй иргэн" аяныг 4 дүгээр сарын 10-наас 5 дугаар сарын 10-нд "Хаягийн зөрчилгүй сум" аяныг 06 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 30-ныг хүртэл зохион байгуулсан.




Эдгээр ажлуудыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мэдээллийн технологийн газарт албан бичгээр хандан 2013 оноос хойш 16 нас хүрээд иргэний үнэмлэхээ аваагүй болон 25, 45 нас хүрээд иргэний үнэмлэхээ сунгуулаагүй, хаяг тодорхойгүй төлөвтэй байгаа иргэдийн судалгааг гаргуулан авч сумдын улсын бүртгэгчид





болон багийн Засаг даргын ажлын алба, хэсгийн ахлагч нартай хамтран иргэдэд мэдээлэл хүргэсэн.

Мөн Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж буй Төмөр замын болон төрийн байгууллагуудад албан бичиг хүргүүлж иргэдийн хаягийн зөрчлийг арилгуулахаар үүрэг чиглэл өгсөн.



Үүний үр дүнд хаяг тодорхойгүй төлөвтэй 69 иргэн, оршин суугаа хаягаас өөр хаягт амьдарч ажиллаж буй 168 иргэн, нийт 237 иргэний хаягийн зөрчлийг арилгасан. Иргэний үнэмлэхийг шинээр авах болон сунгуулах иргэдийн 93,9 хувь нь бүртгэлд хамрагдсан.

Тайлант онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 4364, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 595, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1258, архивын чиглэлээр 583 бүртгэл шалгаж нийт 976 зөрчил илрүүлж арилгах боломжтой 806 зөрчлийг арилгуулсан.

Бүртгэлийн багц хууль шинэчлэгдэн батлагдаж, мөрдөж эхэлсэнтэй холбоотой мөн бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар илэрч буй алдаа, зөрчил зэрэгт дүгнэлт хийж улсын бүртгэгчдэд 3 удаа зөвлөмж хүргүүлж ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн болон хэлтсийн даргын зүгээс өгч буй үүрэг чиглэлийг үндэслэн улсын бүртгэгчид 5 удаагийн албан бичгээр үүрэг чиглэл өгсөн.

2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан нэгдсэн зөвлөгөөнд бүртгэлийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчил, урьдчилан сэргийлэх арга зам сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн.

Бүртгэлийн хяналтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг Хяналт шалгалтын газарт, Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ажиллагааны мэдээг аймгийн Прокурорын газарт тус тус хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэдийг бүртгэлтэй холбоотой зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд 72 удаагийн сургалтаар нийт 2227 иргэнийг хамруулан сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан.



Аймгийн хэмжээнд шийдвэрлэгдэж буй зөрчлийг сумдаар нь болон төрлөөр нь ангилан сар, улирлаар судалгаа гаргаж хамгийн их үйлдэгдэж буй зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар дараагийн ажлаа төлөвлөн ажилласан. “Зөрчлөөс урьдчилан сэргийлье” самбарыг хийж байршуулсан.



Иргэнд хандаж, хэлтэс рүү ордог шатанд бүртгэлтэй холбоотой хуульд тусгагдсан 21 мэдээлэл бүхий хуудсыг наасан.

Гарын авлагыг А-4 хэмжээтэй цаасанд бүх мэдээллийг багтаан 16 ширхэг нугалбар болгон хэвлүүлж 463 ширхэгийг тараасан.

Иргэний үнэмлэх, шилжилт, төрсний бүртгэл, нас барсны бүртгэлтэй холбоотой мэдээллээр санамж хийж 800 ширхэгийг тараасан.



Төрсний бүртгэл, нас барсны бүртгэлийг хуулиар тогтоосон хугацаанд нь бүртгүүлэхгүй байх асуудал буурахгүй байгаа учир тус бүртгэлүүдтэй холбоотой мэдээллээр гарын авлага бэлтгэн Аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргүүлэн төрөх тасаг,

**Нас Барсны Бүртгэл**

“Иргэний улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 13.1-д нас барагчийн иргэний үнэмлэх болон эмнэлгийн магадлагаа зэргийнхэнд 3 хоногийн дотор нас хийлгэнэ гэж

15.24.1 Тогт улсын бүртгэлийг хэлмэжээ

Дорноговь аймг

ТАНД ГҮН ЭМГЭНЭЭ ИЛЭРХИЙЛЬЕ

**Төрсний Бүртгэл**

“Иргэний улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 6.1-д эцэг, эх, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл эрх бичий байгичлаллагын төлөөлөгч хэргийн 30 хоногийн баримт бичиг бүртгэлд бүртгэгдсэн байна.

15.24.1 Тогт улсын бүртгэлийг хэлмэжээ

Дорноговь аймгийн улсын бүртгэлийн хэлтэс


Бүртгэл хийх өдөр 15.24.1-д тус тусын үйлчилгээний үйлчилгээний төлөөлөгчид 30 хоногийн дотор иргэний үнэмлэхийг авчирна

Бүртгэл хийх өдөр 15.24.1-д тус тусын үйлчилгээний үйлчилгээний төлөөлөгчид 30 хоногийн дотор иргэний үнэмлэхийг авчирна



өрхийн эмнэлгүүдээр дамжуулан иргэдэд хүргүүлж эхлээд байна.

Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс "Зөрчлөөс урьдчилан сэргийлэх" ажлын хүрээнд хуулийн хугацаанд бүртгэлээ хийлгэхийг сануулсан ТАТ, ТҮЛХ гэсэн бичиг бүхий санамжуудыг 8 сумын иргэд олноор үйлчлүүлдэг 60 байгууллагын хаалган дээр байрлуулсан.



Дээрх урьдчилан сэргийлэх ажлууд хийгдсэнээр энэ оны эхний 5 сарыг сүүлийн 5 сартай харьцуулахад бүртгэлд эзлэх зөрчил 3.72 хувиар буурсан байна.

Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2 хуулийн этгээд, 489 хүнд 10895,0 мяган төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.

#### **Дотоод хяналтын чиглэлээр:**

Тус хэлтсийн даргын баталсан 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн "Төрөлжсөн болон байгууллагын архивт хяналт шалгалт хийх удирдамж"-ийн дагуу Хяналтын улсын байцаагчаар ахлуулсан ажлын хэсэг 11 дүгээр сарын 4-5-ны өдөр эх нотлох баримт бичгийн төрөлжсөн архивт, 6-8-ны өдөр байгууллагын архив болон 2019 оны 06 дугаар сар буюу сүүлийн хагас жилийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илтгэх хуудсаар хэлтсийн даргад танилцуулсан.





Уг хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг хэрхэн арилгах талаар архивын мэргэжилтэн болон албан хэрэг хөтлөлтийн ажилтан, бусад холбогдох улсын бүртгэгч нарт зөвлөгөө өгч, зөрчлийг 12 дугаар 11-ний өдөр хүртэлх хугацаанд арилгах хугацаатай үүрэг өгч ажилласан. Энэ хүрээнд сумын улсын бүртгэгчид нас баралтын болон харьяатаас гарсан иргэдийн санг цэгцэлж, цахим файл үүсгэхээр ажиллаж байна.

### **Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд:**

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн нээлттэй, ил тод, шуурхай байдлыг хангах зорилтын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомж, түүний хэрэгжилт бусад цаг тухайд нь хүргэж, сурталчлан тус хэлтсийн удирдлага, алба хаагч нарыг орон нутгийн телевизийн нэвтрүүлэг, ярилцлагад оролцуулах ажлыг зохион байгуулсан.

1. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, сургалт, зөвлөгөөн, бусад цаг үеийн арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд орон нутгийн DSB телевизэд 2 удаагийн ярилцлага, “Өнөөгийн Дорноговь” хэвлэлд 2 мэдээлэл хэвлүүлсэн.

2. Улсын бүртгэлийн багц хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан хуулийг сурталчлах төлөвлөгөөг хагас жилээр батлан гаргаж ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу хууль сурталчлан таниулах ажлыг төрийн 72 байгууллагын 2227 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан.

3. Хэлтсээс хэрэгжүүлсэн арга хэмжээ болон цаг үеийн мэдээ мэдээллийг байгууллагын <http://burtgel.do.gov.mn> цахим сайт болон нүүр номын хуудсанд байрлуулж, иргэдэд тараасан. Мөн 7 хоног бүрийн ажлын мэдээллийг АЗДТГ-т хүргүүлж хэвшсэн. .

4. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн ажил үйлчилгээний чиглэлээ иргэд олон нийтэд ил тод байлгах зорилгоор үйлчилгээний танхимын дэргэд Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр самбар шинээр байрлуулсан.

Мөн бүртгэлийн баримт бичгийн бүрдүүлбэр, төлбөр хураамжийн тухай мэдээллийг агуулсан самбарыг шинэчлэн байрлуулсан.



5. Тус хэлтсийн үйлчилгээний танхимд үйлчилж байгаа улсын бүртгэгчдийн нэр, ажлын байрны зорилт, чиг үүргийг тодорхой бичсэн танилцуулгыг өмнө нь байрлуулсан.





6. Үйлчилгээний танхимд байрлуулсан самбарт иргэний бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалт бүхий гарын авлага буюу хайчилбараар тогтмол шинэчилсэн.



**Төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдал:**

Хуульд заасны дагуу байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст Улсын бүртгэлийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн тайлан, 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2019 оны санхүүгийн тайлан, 2019 оны төсөв, төсвийн байгууллагын санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийг тухай бүр хугацаанд нь шинэчлэн нийт 133 мэдээллийг байрлуулсан.

**Санхүү, аж ахуй үйлчилгээний ажлын хүрээнд:**

Улсын бүртгэлийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлангийн аудит хийж "Зөрчилгүй" санал, дүгнэлт өгсөн. Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн гүйцэтгэл 12 дугаар сарын байдлаар 250000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 412190.8 мянган төгрөгийн үйлчилгээний орлогыг олж 412190.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн, орлогын